



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 294

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны буудлын төслийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 154,700,000.00 (нэг зуун тавин дөрвөн сая долоон зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 69,971,527.44 (жаран есөн сая есөн зуун далан нэгэн мянга таван зуун хорин долоон төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Зам, тээвэр хөгжлийн яам, “Хөвсгөл-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ, Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн захирал Н.Энхбат, “Хөвсгөл-АЗЗА” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Галбадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн эмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 26.4/ дүгээр тогтоолын хавсралт

Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны буудлын төслийн нэгжийн балансаас шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

д/д	Автомашинь нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нийт үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)	Хүлээн авах байгууллага
1	Тоёото Нисе маркийн автобус, улсын дугаар-56-01 УНУ, арлын дугаар-JXFJX02P500049633	2013/2013	ш	1	56,800,000.00	34,553,333.00	22,246,667.00	Зам тээврийн хөгжлийн яам
2	Тоёото Ланд крузейр-76 маркийн, улсын дугаар-56-11 УНУ, арлын дугаар-JTEEB71J407023526	2014/2014	ш	1	97,900,000.00	28,418,194.44	69,481,805.56	"Хөвсгөл-А33А" ТӨХК
				2	154,700,000.00	62,971,527.44	91,728,472.56	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			2 (хоёр)	154,700,000.00 (нэг зуун тавин дөрвөн сая долоон зуун мянган)	69,971,527.44 (жаран есөн сая есөн зуун далан нэгэн мянга таван зуун хорин долоон төгрөг дөчин дөрвөн мөнгө)	91,728,472.56 (ерэн нэгэн сая долоон зуун хорин найман мянга дөрвөн зуун далан хоёр төгрөг тавин зургаан мөнгө)	